МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 23 өдөр Дугаар А/277. Мөрөн сум

Зам засвар, арчлалтын ажлыг хүлээж
авах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 35.1.6, 48 дугаар зүйлийн 48.1, 48.6, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2, 12.1.5, 28 дугаар зүйлийн 28.1, Засгийн газрын 2020 оны 246, 2021 оны 212 дугаар тогтоол, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 49 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын Боомын даваany зам засвар, арчлалтын ажлыг хүлээж авах чиг үүрэг бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Б.Энхжаргал- (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга)
Гишүүд: М.Эсмэдэх – (Бүрэнтогтох сумын ИТХ-ын дарга)
Л.Аззаяа – (Бүрэнтогтох сумын Засаг дарга)
Э.Ариунтунгалаг – (Бүрэнтогтох сумын Засаг даргын орлогч)
Ж.Нацагдорж (Онцгой байдлын газрын Гал түймрийн хяналтын улсын байцаагч, хошууч)
Э.Наранчимэг - ("Хөвсгөл барилга захиалагчийн төв" ОНӨААТҮГазрын хяналтын инженер)
Ж.Жавзанпагма - (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга)
С.Мөнхбаяр – (Бүрэнтогтох сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагч)
Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл:
Б.Энхцэцэг - ("Эрдэнийн харгуй" ХХК-ийн захирал)
Ашиглагч байгууллагын төлөөлөл:
С.Пүрэвдорж - (Бүрэнтогтох сумын Их-Уул багийн Засаг дарга)
Г.Мөнхбаяр - (Бүрэнтогтох сумын Сангийн далай багийн Засаг дарга)

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:
Э.Аззаяа - (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

2. Зам засвар, арчлалтын ажлыг ашиглалтад оруулах үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомж, Барилга, хот байгуулалтын сайдын зөвлөмж, аймгийн Мэргэжлийн хяналтын газрын зөвлөмж, коронавируст халдвар (ковид-19)-аас

урьдчилан сэргийлж, халдвар хамгааллын дэглэмийг баримтлан зохион байгуулж, комиссын ажлын тайлан, шийдвэрийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор танилцуулахыг комиссын дарга (Б.Энхжаргал)-д даалгасугай.

3. Зам засвар, арчлалтын ажлыг ашиглалтад оруулсантай холбоотой баримт бичгийг бүрдүүлэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасаг болон холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгөхийг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга (Э.Аззаяа)-д үүрэг болгосугай.

4. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн чанаргүй гүүрийн засварын ажил хүлээн авсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгүүлэхийг анхааруулсугай.

5.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т үүрэг болгосугай.

ДАРГА Ш.ИДЭРБАЯСГАЛАН